



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А173

Номгон

Их богдын байгалийн цогцолборт газрын
менежментийн төлөвлөгөө боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Их Богдын байгалийн цогцолборт газрын менежментийн төлөвлөгөө (2024-2028) боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Бат-өлзий - Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Л.Мандал – Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Д.Цэвэгдорж - Эрдэнэцогт сумын Засаг дарга

О.Мөнхбат - Баянлиг сумын Засаг дарга

Д.Мөнхжаргал - Жаргалант сумын Засаг дарга

Г.Доржбат - Галуут сумын Засаг дарга

Р.Батжаргал - Жинст сумын Засаг дарга

Б.Бурмаа - Богд сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Г.Амаржаргал - Баянговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга


Нарийн бичгийн дарга: Б.Намуун -Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Менежментийн төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-тай уялдуулан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөлтийн арга зүй”-н дагуу боловсруулах ажлыг зохион байгуулж, тайлагнахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Бат-Өлзий)-д үүрэг болгосугай.

842310157

2.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН